

Аж ахуйн нэгжүүдийн орлого, зардлын тайлагналд НӨАТ-ын шинэчлэлийн үзүүлсэн нөлөө

The Effect of Value-added Tax Reform on the Entity Income and Expense Report

Б. Алтан-Эрдэнэ¹, Б. Мягмарсүрэн²

Хураангуй

Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) нь Монгол улсын төсвийг бүрдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой татварын төрөл юм. Энэхүү судалгаагаар бид НӨАТ-ын шинэчлэл нь далд эдийн засгийг багасгахад хувь нэмрээ оруулж чадаж байна уу гэдгийг аж ахуйн нэгж, байгууллагуудын орлого, зардлын үзүүлэлтүүд дээр үндэслэн танадахыг зорьлоо. Ингэхдээ Дархан-Уул аймагт үйл ажиллагаагаа явуулдаг 194 компанийн 2014-2016 онуудын татварын тайлангийн үзүүлэлтүүдийг ашиглан ялгаврын ялгавар (difference-in-differences) аргаар тогтмол нөлөөний загварыг (fixed effect model) үнэлэхэд жижиг аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого дундажаар 108.9 сая төгрөгөөр нэмэгдэж тайлагнагдсан ба энэ хэрээр далд эдийн засгийг багасгаж чадсан байна. Мөн НӨАТ төлөгч жижиг аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого дундажаар 135.0 сая төгрөгөөр нэмэгдэж харин НӨАТ төлөгч бус жижиг аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого буурч тайлагнагдсан нь иргэд сугалаанд оролцохын тулд НӨАТ төлөгч аж ахуйн нэгжүүдээр үйлчлүүлэхийг илүүд үзэж буйтай холбоотой гэж үзэж байна.

Түлхүүр үгс: НӨАТ-ын шинэчлэл, далд эдийн засаг, тайлагнал, ялгаврын ялгавар үнэлэгч

Abstract

The value-added tax is a significant component of central government revenue. In this study, we attempted to identify whether value-added tax reform lightens some part of the shadow economy through analyzing the entity income and expense reports. We estimate fixed effect model employing difference-in-difference estimator using a panel of 194 entities of Darkhan-Uul aimag from 2014 to 2016 and find that income report of small entities has increased on average by 108.9 million tugrugs; thus value-added tax reform does light the shadow. Also, sales income of the VAT payer entities has increased on average by 135.0 million tugrugs while sales income of VAT non-payer entities has decreased. It is because customers prefer VAT payer entities over non-payers in order to participate VAT lottery.

Keywords: value-added tax reform, shadow economy, reporting, difference-in-difference estimator

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн багш, доктор
E-mail: altanerdene.b@num.edu.mn

² МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургууль, Эдийн засгийн онолын тэнхимийн багш, доктор
E-mail: myagmarsuren.b@num.edu.mn

Оршил

Татвар бол нийгмийн баялагаас хүртэж буйн төлөө төлөх төлөөс буюу бүх нийтийн хүлээсэн үүрэг тул түүний тусламжтайгаар эдийн засагт зохицуулалт хийж, орлогыг дахин хуваарилж, нийгмийн тэгш байдлыг хангадаг (Алтанзаяа, 2016).

Манай улс шиг байгалийн баялгаас хэт хараат, эдийн засгийн хөгжил сул орны хувьд татварын бодлогоор дамжуулан эдийн засгийн бүтцээ сайжруулах, бусад салбаруудаа дэмжих, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох боломжоор хангах зэрэг бодлогын улмаас улсын төсвийн ачаалал даах чадварыг нэмэгдүүлэх, орлогын эх үүсвэрийг татвараар дамжуулан бүрдүүлэхэд татвар ногдуулалтын үндэслэлийг сайжруулах, татварын хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих асуудал чухалд тооцогдсоор ирсэн.

Уг шалтгаанаар Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг татварын бодлогоор дэмжих, татварын энгийн ойлгомжтой, тэгш шударга байх зарчмыг хангах, олон улсын жишигт нийцүүлэх чиглэлээр одоогийн мөрдөгдөж байгаа нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ын хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдөр батлаж, 2016 оны 01 сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжүүлж байна (Татварын Ерөнхий Газар - ТЕГ, 2015).

Улсын төсвийн татварын орлогын 17-31 хувийг бүрдүүлдэг НӨАТ-ын суурийг нэмэгдүүлэхэд бүртгэлийн систем, хэрэглэгчийн системүүдийг шинээр нэвтрүүлж, иргэд/хэрэглэгчдийг хяналтын тогтолцооны нэг хэсэг болгох замаар далд, нуугдмал байгаа орлогыг ил болгох зорилго бүхий НӨАТ-ын хууль нь далд эдийн засгийг ил болгож байна уу гэдгийг

танадах шаардлага зүй ёсоор урган гарч байгаа юм. Манай улсад төрийн бодлогын үр нөлөөг эконометрик аргаар судалсан туршлага цөөн байдаг ба бидний судалгаа нь энэ сэдвээр хийгдэж байгаа анхны ажил гэдгээрээ давуу талтай юм.

Энэхүү өгүүлэл нь үндсэн дөрвөн хэсгээс бүрдэх ба эхний хэсэгт сэдвийн судлагдсан байдал, хоёрдугаарт тоон баримтууд, гуравдугаарт судалгааны арга зүй, өгөгдлийн талаар, дөрөвдүгээрт үнэлгээний үр дүнг харуулсан ба эцэст нь судалгааны дүгнэлт, саналаа оруулсан болно.

Сэдвийн судлагдсан байдал

Монгол Улсын төсвийн татварын орлогын 17-31 хувийг бүрдүүлж байгаа НӨАТ-тай холбоотой судлаачдын бүтээл олон байдаг. Тэдгээр нь НӨАТ-ын бүртгэл тайлагнал, дарамтыг бууруулах, бааз суурь, хамруулалт, хяналт хэрэгжилтийг боловсронгуй болгох гэх мэт олон талаар судалсан байна. Тухайлбал, Гантулга нар (2010) НӨАТ нь аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ)-уудыг нэг буюу үнэн зөв санхүүгийн тайлан мэдээлэл бэлтгэдэг болгох, татварын хөндлөнгийн мэдээллийг цуглуулах найдвартай хэрэгсэл, эх үүсвэр болгох замаар далд эдийн засгийг багасгах, улмаар арилгах гэх мэт ач холбогдол бүхий татвар гэдгийг онцолсон ба НӨАТ-ыг татварын харилцаанд оролцогч бүх субъектуудийн ашиг сонирхолд нийцэхүйц зөв бүтэц, зөв зохион байгуулалттай, зөв систем болгон сайжруулах арга замыг бий болгох хэрэгтэй гэж үзсэн. Үүний тулд НӨАТ-ын босгыг өсгөх, иргэд жилийн турш худалдан авсан бараа үйлчилгээнд төлсөн НӨАТ-аа жилд нэг удаа буцаан авах боломжийг олгох, ядуу хэсгийн татварын ачааллыг бага байлгах үүднээс өргөн хэрэглээний зарим бараа, үйлчилгээнд

татварын багасгасан хувийг хэрэглэх зэрэг аргуудыг санал болгожээ.

Дарьсүрэн (2013) НӨАТ ногдуулах босго хэмжээг нэмэгдүүлэх боломжийг татвар төлөгч 200 аж ахуйн нэгжийг санамсаргүйгээр түүвэрлэх замаар судалсан ба анкетийн аргаар мэдээлэл цуглуулан, шинжлэхэд босго хэмжээг өсгөхөд НӨАТ төлөгчийн тоо, НӨАТ-ын орлого буурах боловч аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ)-ын орлогод эерэгээр нөлөөлнө хэмээн дүгнэсэн байна.

Пунцаг (2014) НӨАТ төлөгчийн бүртгэл, буцаан олголт, бүртгэл тайлагналын байдлыг судлан, хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгын дагуу идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй 100 аж ахуйн нэгжүүдийн нягтлан бодогчдоос санамсаргүйгээр сонгон авч ажиглалт, ярилцлага, анкетын аргаар судалгааны мэдээллийг цуглуулжээ. НӨАТ-ын бүртгэлийн үйл явцад хуурамчаар бүртгэлийг хөтлөх, хууль стандартын дагуу бус ашгийн төлөө хөтлөх хандлага ажиглагдаж байна. Монгол улсын НӨАТ-ын хэрэгжилтийн өнөөгийн байдал нь татвар төлөгчөөр бүртгүүлэх босгын шаардлагыг хангасан ч бүртгүүлээгүй, баримт хуурамчаар үйлдэгдэх, буцаан олголтын үйл явцад хүндрэлтэй асуудал гарах зэрэг олон шийдвэрлэвэл зохих асуудлууд бий учраас НӨАТ-ын бүртгэл тайлагналын асуудлыг нарийн боловсронгуй болгож хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзжээ.

Сүхээ (2014) НӨАТ-ын тухай хуулийн үйлчлэл нь татвар төлөгч болон татварын албаны хооронд их зөрчил үүсгэж ирсэн бөгөөд цаашид ч энэ байдал үргэлжлэх өндөр магадлалтай гэж тусгажээ. Уг зөрчил үүсгэхэд ихэнх татвар төлөгч, ялангуяа

жижиг татвар төлөгч хуулийн этгээд болон иргэдийндунд НӨАТ-ын талаар зөв ойлголт төлөвшөөгүй, одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн зарим зүйл, заалтууд амьдралд нийцэхгүй байгаа, луйварчид хуулийн хийдлийг ашиглан олон мянган татвар төлөгчийг хохироосон хэрэг гарсан, Сангийн сайд, Улсын Дээд Шүүхийн эрх бүхий албан тушаалтнуудын хуулиас давж гаргасан шийдвэр гэх мэт олон хүчин зүйлүүд нөлөөлдөг гэж үзэн хуулийн зүйл, заалтуудыг өөрчлөх хувийн санал, зөвлөмжөө тусгасан байна.

Ундармаа нар (2016) НӨАТ-ын бүртгэл, тайлагналын асуудал нь татвар төлөгч, татварын албаны хооронд зөрчил, маргаан үүсгэж байна гэж үзэн, уг асуудлын хүрээнд аж ахуйн нэгжүүд татварын хууль, стандартад нийцүүлж бүртгэж чадахгүй байгааг тодорхойлж, НББОУС-12 “Орлогын албан татвар”-д заасны дагуу зохицуулан бүртгэх боломжтой гэж үзсэн.

Өнөрмөнх (2017) Монгол улсад НӨАТ-ын өнөөгийн чиг хандлагыг тодорхойлж, шинэ хууль гарсантай холбоотой хэрэгжиж байгаа мэдээллийн технологийн системийг ашиглан хяналтыг сайжруулах боломж, арга замыг судлан дүгнэлт өгөх зорилгын дагуу аж ахуйн нэгжийн тоон мэдээлэлд үндэслэн дашбоард арга хэрэгслийг ашиглаж график байдлаар дүрслэн гаргасан. Цуглуулсан статистик тоо баримтаас үзэхэд Монгол улсын НӨАТ нь ААНОАТ-ын ногдуулалт, хураалттай харьцуулахад харьцангуй үр дүнтэй татвар болох нь тогтоогдсон ба НӨАТ-ын урамшууллын систем нь бусад татварын ногдуулалтад чухал ач холбогдолтой болохыг онцолсон байна. Цаашдаа Монгол улсын татварын тогтолцооны ирээдүйн чиг хандлагад хэрэглээний татвар НӨАТ-ын үүрэг байнга өсөн нэмэгдэх бөгөөд

түүнийг нарийвчлан судалж, үндсэн бүтцийг нь өөрчлөхгүйгээр хөгжүүлэх шаардлагатай гэж үзээд өнөөгийн НӨАТ-ын системийг дашбоардаар дамжуулан илүү боловсронгуй болгох саналыг дэвшүүлжээ.

Энхсүрэн нар (2017) төр цахим төлбөрийн баримтын системийг ашиглан эцсийн хэрэглэгчээр дамжуулан ААНБ-ын НӨАТ-ын падааны наймааг таслан зогсоох, орлогоо нуух, татвараас зайлсхийх асуудлыг шийдвэрлэж чадаж байгаа эсэхийг тодорхойлохыг зорьж, иргэдийн татварын боловсролыг дээшлүүлж, бараа, үйлчилгээний худалдан авалтын баримтыг и-баримтанд шивэх хөшүүргийг нэмэгдүүлэх нь НӨАТ-ын орлогыг өсгөж байна гэжээ. Уг дүгнэлтэнд үндэслэн НӨАТ төлөгчдийг урамшуулж байгаа сугалааны хэлбэрээс татгалзаж, буцаалтын 20 хувийг нэмэгдүүлэх, экспортод гаргаж байгаа бүтээгдэхүүний хувьд жижиг, дунд үндэсний үйлдвэрлэгчдийн эцсийн бүтээгдэхүүнийг дэмжих гэх мэт саналыг дэвшүүлсэн байна.

Хишигбаяр нар (2017) НӨАТ-ын хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжсэнээр төсөвт орох НӨАТ-ын орлогын хэмжээ мэдэгдэхүйцээр өссөн эерэг үзүүлэлттэй байгаа боловч зарим худалдааны төв, зах, дэлгүүрийг бүрэн нэгдсэн системд хамруулж чадаагүйгээс хэрэглэгчдэд цахим төлбөрийн баримт хэвлэж өгдөггүй зөрчил гарсаар байгаа нь татварын тэгш шударга зарчмыг алдагдуулж, хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна гэж дүгнээд тоног төхөөрөмж, программ хангамж худалдан авахад ААНБ-уудад хөнгөлөлт үзүүлэх, татварын албаны сургалтыг тогтмолжуулах, татварын боловсролыг ерөнхий боловсрол, их дээд сургуульд заавал судлах хичээл болгон оруулах зэрэг санал гаргажээ.

Тоон баримтууд

Албаны эх сурвалжид тэмдэглэсэнээр татварын шинэчилсэн хуульд e-barimt гэх шинэ бүртгэлийн цахим системийг нэвтрүүлснээр орлого зарлагатай холбоотой маргааныг багасгах, татвараас зайлсхийх, зугтах асуудлыг бууруулах замаар бизнест ээлтэй, тэгш шударга өрсөлдөх орчныг бий болгох эрхзүйн орчныг бүрдүүлснээрээ онцлогтой ба мөн тухайн системд НӨАТ-ын падааныг бүртгүүлсэн иргэнд жилд нэг удаа урамшуулал олгохыг тусгаснаар иргэд том, жижиг гэлтгүй ААНБ-уудаас худалдан авалт хийж, үйлчилгээ авсан дүнгээрээ и-баримтаа шаардаж авдаг болох ба энэ нь хуулийн хэрэгжилтэд татвар төлөгчдийн оролцоотойгоор хяналт тавих, татвар төлөгчдийг урамшуулах, бүртгэл, хяналтын тогтолцоог сайжруулах, далд эдийн засгийг ил гаргах ач холбогдолтой хэмээн үзжээ.

Улсын төсвийн орлогод эзлэх НӨАТ-ийн хувийг Хүснэгт 1-д харуулав.

Хууль хэрэгжсэнээр бизнес эрхлэгч 38,825 татвар төлөгч хувь хүн, хуулийн этгээд стандартын шаардлага хангасан бүртгэлийн машин хэрэглэж, мэдээллийг төлбөр тооцооны бүртгэлийн системд илгээж хэвшсэн бөгөөд НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлэх босгыг нэмэгдүүлсэн боловч борлуулалтын орлогын хэмжээ хуулийн шаардлага хангасан 2,708 татвар төлөгч шинээр НӨАТ суутган төлөгчөөр бүртгэгдсэн байна (ТЕГ).

Татварын бүртгэл сайжирч, татварын албанд бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн тоо нэмэгдсэнтэй холбогдуулан өнгөрсөн оны гүйцэтгэлээр дотоодын бараанд ногдуулдаг НӨАТ-ын орлогын хэмжээ 553.2 тэрбум төгрөгт хүрсэн нь 2015 оны

Хүснэгт 1. НӨАТ-ын татварын орлого, улсын төсөвт эзлэх хувь, сая төгрөгөөр

Он	Нийт орлого ба тусламжийн дүн	Татварын орлого	Нэмэгдсэн өртгийн татвар	НӨАТ-ын татварын орлогод эзлэх хувь	НӨАТ-ын нийт орлогод эзлэх хувь
2006	1,360,410	1,128,141	241,283	21.39%	17.74%
2007	1,880,489	1,502,310	265,051	17.64%	14.09%
2008	2,170,370	1,890,897	368,049	19.46%	16.96%
2009	1,993,996	1,620,550	325,956	20.11%	16.35%
2010	3,122,464	2,688,236	579,120	21.54%	18.55%
2011	4,482,026	3,668,308	1,114,383	30.38%	24.86%
2012	4,981,777	4,203,321	1,296,451	30.84%	26.02%
2013	5,986,925	5,072,793	1,435,092	28.29%	23.97%
2014	6,316,523	5,157,025	1,371,725	26.60%	21.72%
2015	5,983,398	5,118,979	1,049,589	20.50%	17.54%
2016	5,835,044	4,950,950	1,140,721	23.04%	19.55%
2017	7,922,489	6,302,610	1,619,224	25.69%	20.44%

Эх үүсвэр: www.1212.mn

гүйцэтгэлтэй харьцуулахад 70 орчим тэрбум төгрөгөөр өссөн байна. Мөн 2016 онд татвар төлөгч иргэн цахим төлбөрийн баримтын системд хэрэглэгчээр бүртгүүлэн 19 удаагийн сугалааны тохирлоор 3.6 тэрбум төгрөгийн сугалааны урамшуулал олгосон байна (ТЕГ).

Дээрх статистик мэдээллийг харахад НӨАТ-ын орлого өмнөх оноос нэмэгдсэн боловч энэхүү нэмэгдэлтийг зөвхөн татварын шинэчлэлтэй холбон тайлбарлах нь буруу юм. НӨАТ-ын орлого нэмэгдэхэд нөлөөлсөн маш олон шалтгаан байгаа ба тэдгээрийн нөлөөллийг тооцсоны дараа татварын шинэчлэлийн нөлөөг үнэлэхэд статистик ач холбогдолтой гарч байвал татварын бодлого үр нөлөөгөө өгч байна

Загварын тавил:

$$Dep_{it} = \beta_0 + \beta_x X_{it} + \beta_{sml} SML_{it} + \beta_{law} LAW_{it} + \beta_{DID} SML_{it} * LAW_{it} + \delta_i + \varepsilon_{it}$$

Үүнд: i – аж ахуйн нэгж, байгууллага; t – хугацаа; Dep – хамааран хувьсагчид (борлуулалтын орлого, борлуулалтын өртөг гэх мэт); β – регрессийн параметрууд; X – үл хамаарах хувьсагчид (эдийн засгийн өсөлтийн хувь, үйлдвэрлэлийн салбар); SML – жижиг бизнесийг илэрхийлэх дамми хувьсагч; LAW – НӨАТ-ын шинэ хууль үйлчилж буй оныг илэрхийлэх дамми хувьсагч; δ – ААНБ-ийн хувийн онцлог; ε – регрессийн санамсаргүй алдаа.

хэмээн үзэж болох юм. Иймээс бид дараах хэсэгт өгүүлсэн арга зүйг ашиглан татварын бодлогын нөлөө байгаа эсэхийг тодорхойлохыг хичээсэн юм.

Судалгааны арга зүй, тоон мэдээ

Бид энэхүү судалгаандаа Дархан-Уул аймагт идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй 194 аж ахуйн нэгж, байгууллагыг санамсаргүй түүврийн аргаар сонгон авч, тэдний 2014-2016 онуудын татварын тайланд тусгагдсан орлого, зардлын үзүүлэлтүүдийг 2010 оны үнэд шилжүүлсэн байдлаар (ДНБ-ий дефлятороор засварлан) ашигласан. Үнэлгээг хийхэд тогтмол нөлөөний загвар (fixed effect model)-ыг сонгосон ба загварын тавилыг дараах байдлаар тодорхойлж байна.

Бид татварын хуулийн шинэчлэл нь борлуулалтын орлого, борлуулалтын өртөг, борлуулалт-удирдлагын зардал, орлогын татварын зардлын тайлагналд хэрхэн нөлөөлснийг тодорхойлох зорилгоор тэдгээрийг хамааран хувьсагчдаар сонгож авсан. Өөрөөр хэлбэл шинэ хууль хэрэгжсэнээр далд байсан орлого ил болж хууль хэрэгжихээс өмнө тайлагнаж байсан дүнгээс ялгаатай байдлаар тайлагнагдаж чадсан эсэхийг тодорхойлох

юм. Түүнчлэн, аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого нь эдийн засгийн өсөлтөөс хамаардаг тул эдийн засгийн өсөлтийн хувийг үл хамаарах хувьсагчаар сонгосон. Мөн салбарын ялгаатай байдлыг тооцох зорилгоор салбарын хувьсагчийг ашигласан.

Регрессийн хувьсагчдын тодорхойлолтыг Хүснэгт 2-т харуулав.

Судалгаанд ашиглагдсан хувьсагчдын

Хүснэгт 2. Хувьсагчдын тодорхойлолт

Хувьсагчид	Тайлбар	Эх сурвалж
sales	Борлуулалтын орлого, мянган төгрөг, 2010 оны үнээр	Дархан-Уул аймгийн Татварын хэлтэст хүргүүлсэн “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан” (Маягт ТТ-02)-ийн нэгтгэл
salecost	Борлуулалтын өртөг, мянган төгрөг, 2010 оны үнээр	
admcost	Борлуулалт-удирдлагын зардал, мянган төгрөг, 2010 оны үнээр	
inctax	Орлогын татварын зардал, мянган төгрөг, 2010 оны үнээр	
sector	Үйлдвэрлэлийн салбарууд, 1 – барилга угсралт; 2 – бусад; 3 – жижиглэн, бөөний худалдаа; 4 – үйлчилгээ; 5 – хүнс, хөдөө аж ахуй; 6 – зочид буудал, зоогийн газар	
dumvat	НӨАТ төлөгч байгууллагыг илэрхийлэх дамми, НӨАТ төлөгч бол 1, үгүй бол 0 утга	
gdp_growth	Эдийн засгийн өсөлт, хувиар	Дэлхийн банкны мэдээллийн сан
small	Жижиг бизнесийн байгууллагыг илэрхийлэх дамми, жижиг аж ахуйн нэгж бол 1, үгүй бол 0 утга	Борлуулалтын орлого 250 сая төгрөгөөс бага бол жижиг ААН ³
dumlaw	НӨАТ-ын шинэ хууль үйлчилж буй оныг илэрхийлэх дамми, 2016 бол 1, бусад 0 утга	
DID	НӨАТ-ын шинэ хуулийн нөлөөг илэрхийлэх дамми, <i>small</i> болон <i>dumlaw</i> хувьсагчуудын үржвэр байдлаар үүсгэсэн	

Хүснэгт 3. Тодорхойлох статистик

Хувьсагчид	Ажиглалтын тоо	Дундаж	Стандарт хазайлт	Хамгийн бага утга	Хамгийн их утга
sales	579	140,497.7	351,709.7	0.0	3,159,560.4
salecost	571	98,915.2	286,420.7	0.0	3,083,255.2
admcost	579	37,855.7	91,255.7	0.0	1,186,596.5
inctax	582	-1,048.6	6,929.0	-67,971.1	37,971.1
gdp_growth	582	3.739	2.988	0.976	7.885
sector	582	3.562	1.198	1	6
dumvat	582	0.479	0.500	0	1
small	582	0.742	0.438	0	1
dumlaw	582	0.333	0.472	0	1
DID	582	0.247	0.432	0	1

³ Жижиг, дунд үйлдвэрийн тухай Монгол улсын хуулийн 5.1.5 заалтыг үндэслэн

Хүснэгт 4. Корреляцийн коэффициент

	gdp_growth	sector	dumvat	small	dumlaw	DID
sales	0.063	-0.025	0.305 ***	-0.528 ***	-0.036	-0.176 ***
salecost	0.059	-0.058	0.306 ***	-0.500 ***	-0.038	-0.167 ***
admcost	0.018	0.074 *	0.196 ***	-0.404 ***	-0.005	-0.139 ***
inctax	0.122 ***	-0.083 **	-0.096 **	0.114 ***	-0.042	0.016
gdp_growth		0.000	0.000	0.000	-0.655 ***	-0.531 ***
sector			-0.183 ***	0.060	0.000	0.020
dumvat				-0.402 ***	0.000	-0.136 ***
small					0.000	0.338 ***
dumlaw						0.811 ***

Тэмдэглэгээ: ***, **, * нь харгалзан 1, 5, 10 хувийн ач холбогдлын түвшинг илэрхийлнэ.

тодорхойлох статистикийг корреляцийн матрицын хамт харгалзан Хүснэгт 3, Хүснэгт 4-т тус тус харуулав.

Өмнө дурдсан загварыг ялгаврын ялгавар (Difference-in-differences, DID) үнэлэгчийг ашиглан үнэлсэн ба энэхүү арга нь бодлогын нөлөө (policy effect)-г тооцож гаргадаг статистик-эконометрикийн аргуудын нэг бөгөөд НӨАТ-ын шинэ хуулийн нөлөөг тооцоход хамгийн тохиромжтой арга гэж үзсэн. DID аргыг ашиглахын тулд дараах үндсэн гурван шаардлага хангагдсан байх ёстой.

1. Зорилтот бүлэг, хяналтын бүлэг хэмээх хоёр үндсэн бүлэг байх ба энэ хоёр нь хоорондоо ялгагдах боломжтой байх: Энэхүү ажилд зорилтот бүлгээр жижиг аж ахуйн нэгжийг, хяналтын бүлгээр жижиг бус аж ахуйн нэгжийг сонгон авсан. Шинэчилсэн хуулийн гол зорилтот бүлэг бол орлого нь тодорхойгүй байдаг жижиг аж ахуйн нэгжүүд бөгөөд тэдгээрийн орлогыг

иргэдийн хяналтын⁴ тусламжтайгаар ил болгох явдал юм. Харин жижиг бус аж ахуйн нэгжүүд тодорхой хэмжээнд орлогоо тайлагнадаг, харьцангуй ил байдаг гэж үзсэн тул хяналтын бүлгээр сонгон авах нь зөв гэж үзлээ. Жижиг бус аж ахуйн нэгжүүдийн татварын шинэчилсэн хууль хэрэгжихээс өмнөх болон дараах борлуулалтын дундаж орлогууд ялгаатай эсэхийг t тестээр шалгахад $t=1.65$, $p\text{-value}=0.106$ гарсан нь тэдгээр орлогууд хоёр хугацааны хооронд ялгаагүй гэсэн статистик дүгнэлт хийж болохоор байна. Энэ нь бидний сонгож авсан бүлэг хяналтын бүлэг болж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлж байна.

2. Бодлого хэрэгжүүлэхээс өмнөх ба хойшхи хугацааны тоон мэдээ байх: Судалгаанд ашиглагдаж буй тоо мэдээ нь НӨАТ-ын шинэчилсэн хууль хэрэгжихийн өмнөх хугацаа буюу 2014-2015 болон хойшхи хугацаа болох 2016

⁴ и-баримт шаардаж авах замаар

онуудыг хамарч байгаа.

3. Нөлөөг нь тооцох гэж буй бодлоготой зэрэгцээд өөр ижил төрлийн бодлого хэрэгжээгүй байх: 2016 онд НӨАТ-ын шинэчилсэн хуулийн хэрэгжилттэй зэрэгцээд аж ахуйн нэгж рүү чиглэсэн өөр татварын бодлоготой холбоотой өөрчлөлт гараагүй болно. Ийнхүү уг судалгаа нь дээрх гурван шаардлагыг бүрэн хангаж байгаа нь харагдаж байна.

Судалгааны үр дүн

Загварыг STATA программ ашиглан үнэлсэн ба үнэлгээг нийт ААН-ийн хувьд, НӨАТ төлөгч ААН-ийн хувьд, НӨАТ төлөгч бус ААН-ийн хувьд гэсэн 3 ялгаатай хамралтын хүрээтэйгээр хийсэн болно. Хүснэгт 6-д нийт ААН-ийн хувьд хийсэн үнэлгээний үр дүнг харуулав.

F статистик болон Хаусманы тестийн хувьд (1)-(4) тэгшитгэлүүд статистикийн хувьд ач холбогдолтой гарсан боловч

борлуулалтын орлого болон борлуулалтын өртөгийн регрессийн хувьд *DID* хувьсагч 1 хувийн түвшинд ач холбогдолтой байна. Өөрөөр хэлбэл борлуулалт-удирдлагын зардал болон орлогын татварын зардалд хуулийн шинэчлэл нөлөөгүй гэсэн үр дүн гарсан байна. (1)-(2) загварын хувьд, эдийн засгийн өсөлт эерэг, хуулийн хэрэгжилт сөрөг нөлөөтэй байгаа бол бусад хүчин зүйлүүд нөлөөгүй гарсан байна. Тухайлбал, эдийн засаг нэг хувиар өсөхөд (*gdp_growth*) ААН-үүдийн борлуулалтын орлого дундажаар 8,038.5 мянган (8.0 сая) төгрөгөөр нэмэгддэг; хууль хэрэгжсэн үеэс хойш (*dumlaw*) аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого дундажаар 74,768.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Энэхүү судалгааны гол хувьсагч нь *DID* бөгөөд түүний утга нь 108,931.2 мянган төгрөг гарч, статистикийн хувьд ач холбогдолтой байгаа нь бидний зорилтот бүлгээ болгож сонгон авсан жижиг ААН-үүдийн борлуулалтын орлого төдий

Хүснэгт 6. Нийт ААН-ийн хувьд хийсэн үнэлгээний үр дүн

Хувьсагчид	sales (1)	salecost (2)	admcost (3)	inctax (4)
<i>gdp_growth</i>	8,038.5 **	5,670.3 *	803.7	383.4 ***
<i>sector</i>	3,236.3	7,454.6	-57.8	196.0
<i>small</i>	-46,032.5	-151,863.7	1,003.7	-765.0
<i>dumlaw</i>	-74,768.9 **	-70,658.5 **	1,805.1	382.4
DID	108,931.2 ***	96,179.4 ***	842.8	801.6
Сул гишүүн	77,340.4	168,433.3	9,220.1	-1,858.5
F статистик	9.392	6.013	9.578	2.201
Prob.F	(0.000)	(0.000)	(0.000)	(0.000)
Ажиглалтын тоо	579	571	579	582
Компанийн тоо	193	191	193	194
R ²	0.827	0.755	0.830	0.528
Haussman тестийн χ^2	90.66	86.38	41.27	2.91
Prob.	(0.000)	(0.000)	(0.000)	(0.088)

Тэмдэглэлээ: ***, **, * нь харгалзан 1, 5, 10 хувийн ач холбогдлын түвшинг илэрхийлнэ.

дүнгээр нэмэгдсэн байна. Энэ нь хуулийн шинэчлэлээс өмнө далд, нууж байсан орлогыг иргэд и-баримтаа шаардаж авах, и-баримтын систем суурилуулсан байдал зэргээр ил гарч тайлагнагдсан гэсэн утгыг агуулж байгаа юм. Нийт аж ахуйн нэгжүүдийн хувьд тооцсон борлуулалтын дундаж орлого буурсан байхад жижиг аж ахуйн нэгжүүдийн борлуулалт багагүй дүнгээр нэмэгдэж тайлагнагдсан нь тодорхой хэмжээний далд эдийн засгийг ил болгож чадсан, хууль зорилгоо хангаж чадаж байна гэж дүгнэж болохоор байна. Борлуулалтын өртөгийн хувьд борлуулалтын орлогын адил тайлбарлахаар байна.

Хүснэгт 7-д зөвхөн НӨАТ төлөгч ААН-үүдийн хувьд тооцсон үнэлгээний үр дүнг харуулсан бөгөөд НӨАТ төлөгч жижиг ААН-үүдийн борлуулалтын орлого 134,967.6 мянган төгрөг, борлуулалтын өртөг 129,239.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж тайлагнагдсан байгааг харж болно.

Эцэст нь Хүснэгт 8-д НӨАТ төлөгч бус компаниудын тоон мэдээнд хийгдсэн үнэлгээний үр дүнг үзүүлэв. Жижиг аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого жижиг бус аж ахуйн нэгжүүдээс дундажаар 271,439.5 мянган төгрөгөөр бага байгааг, мөн хууль хэрэгжиж эхэлсэнээс хойш нийт ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого 27,372.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгааг харж болохоор байна. Харин хууль хэрэгжсэнээс хойш жижиг аж ахуйн нэгжүүдийн орлого 21,280.2 мянган төгрөгөөр буурсан байгаа ч статистикийн хувьд ач холбогдолтой гараагүй тул буурсан гэж шууд дүгнэж болохгүй. Харин борлуулалтын өртөг 54,181.4 мянган төгрөгөөр буурсан, борлуулалтын орлого ба өртөг хоёр нь хоорондоо шууд хамааралтай байдаг гэж үзвэл орлогын дүнг тодорхой хэмжээгээр буурсан гэж дүгнэж болохоор байна.

Үнэлгээний ерөнхий дүр зургийг харвал иргэд и-баримт өгдөг байгууллагуудаар илүүтэй үйлчлүүлэх болсонтой холбоотой-

Хүснэгт 7. НӨАТ төлөгч компаниудын хувьд

Хувьсагчид	sales (1)	salecost (2)	admcost (3)	inctax (4)
gdp_growth	16,031.2 **	12,454.1 *	869.6	660.3 ***
sector	-41,908.3	-40,975.8	-2,019.6	-3,763.8 ***
small	-190,145.2	-177,992.4	-2,961.9	5,746.4
dumlaw	-71,407.7	-76,483.0	5,645.9	1,896.9
DID	134,967.6 **	129,239.7 **	-4,916.2	-136.6
Сул гишүүн	317,200.3 *	305,407.6 *	19,463.9	2,282.0
F статистик Prob.F	8.356 (0.000)	5.387 (0.000)	9.294 (0.000)	2.249 (0.000)
Ажиглалтын тоо	276	276	276	279
Компанийн тоо	92	92	92	93
R ²	0.813	0.737	0.828	0.539

Тэмдэглэгээ: ***, **, * нь харгалзан 1, 5, 10 хувийн ач холбогдлын түвшинг илэрхийлнэ.

Хүснэгт 8. НӨАТ төлөгч бус компаниудын хувьд

Хувьсагчид	sales (1)	salecost (2)	admcost (3)	inctax (4)
gdp_growth	758.1	-730.9	743.6	128.5 *
sector	-2,346.2	-1,264.9	-1,506.2	284.0
small	-271,439.5 **	-46,627.1 *	-51,216.3 **	-3,715.0 *
dumlaw	27,372.8 **	53,681.4 ***	-14,299.3	-2,345.5 **
DID	-21,280.2	-54,181.4 ***	17,936.9 *	2,795.6 **
Сул гишүүн	282,340.4 ***	57,115.9 ***	578,594.9 **	1,384.5
F статистик Prob.F	12.439 (0.000)	4.939 (0.000)	7.001 (0.000)	1.802 (0.000)
Ажиглалтын тоо	303	295	303	303
Компанийн тоо	101	99	101	101
R ²	0.866	0.721	0.784	0.483

Тэмдэглэгээ: ***, **, * нь харгалзан 1, 5, 10 хувийн ач холбогдлын түвшинг илэрхийлнэ.

гоор НӨАТ төлөгч бус байгууллагуудын орлого буурч, эсрэгээрээ НӨАТ төлөгч байгууллагуудын орлого өссөн байдлаар тайлагнагдсан байгаа нь хууль зорилгоо хангаж чадаж байгаа гэж үзэх үндэслэлтэй болж байна.

Бусад үзүүлэлтүүдийн хувьд удирдлагын зардал болон орлогын татвар нэмэгдсэн гэсэн үр дүн харагдаж байна. Борлуулалтын орлого буурсан, удирдлагын зардал нэмэгдсэн үед орлогын татвар нэмэгдсэн байгаа нь борлуулалтын өртөг борлуулалтын орлогоосоо давж буурсан болохыг илтгэж байна. Энэ нь НӨАТ төлөгч бус жижиг аж ахуйн нэгжүүд бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ илүү хямд өртөгөөр худалдан авч борлуулан үр ашиггүй зардлаа багасгаж чадсан; эсвэл борлуулалтын өртөгт тайлагнагдах өртөг, зардлыг борлуулалт-удирдлагын зардал руу тайлагнасан байх боломжтой юм.

Дүгнэлт

Монгол улсын татварын тогтолцоонд НӨАТ-ын үүрэг оролцоо улам бүр нэмэгдэж

байгаа нөхцөлд татварын шинэчлэлийн үр нөлөөг танадах зорилгоор Дархан-Уул аймгийн 194 аж ахуйн нэгжүүдийн татварын 2014-2016 оны тайлангийн орлого, зардлын үзүүлэлтүүдийг ашиглан энэхүү судалгааг хийсэн. НӨАТ-ын хуулийн шинэчлэл НӨАТ төлөгч болон төлөгч бус аж ахуйн нэгжүүдэд нөлөөлсөн ба ялангуяа жижиг аж ахуйн нэгжүүдийн нуун дарагдуулсан орлогыг ил гаргахад нь энэ хууль зорилгодоо тодорхой хэмжээгээр хүрснийг харуулсан судалгаа болсон. Гэвч бидний энэ судалгаа нь манай улсын бүх аж ахуйн нэгжүүдийг хамруулаагүй тул ийм нөлөө Монгол улс даяар байгаа гэж яаран дүгнэхээс зайлсхийж байна. Иймээс татвар, орлого зардлын тайлантай холбоотой тоон мэдээллүүд нь бэлэн байдаг байгууллагууд тухайлбал, татварын хэлтэсүүд улсын хэмжээн дэх нийт компаниудын өгөгдлийг цуглуулж, өргөн хүрээг хамран иймэрхүү шинжилгээ хийвэл илүү бодитойгоор ямар үр дүнд хүрснийг тодорхойлох боломж байна.

Ашигласан материал

1. Ebeke, C. H., Ehrhart, H. (2011). *Does VAT Reduce the Instability of Tax Revenues?* Working Papers 201124, CERDI.
2. Harrison, G., Krelove, R. (2005). *VAT Refunds: A Review of Country Experience*. IMF Working Paper, WP/05/218.
3. Komal (2013). An Analysis of the Impact of Value Added Tax (VAT) in Delhi. *Global Journal of Management and Business Studies*, 3(3), 277-286.
4. Алтанзаяа, Г. (2016). *Татварын бүртгэл*, сурах бичиг, Улаанбаатар.
5. Гантулга, Г., Өнөржаргал, Ч. (2010). *НӨАТ-ын хуулийн хэрэгжилтэнд тулгамдаж буй зарим асуудлууд*.
6. Дарьсүрэн, С. (2013). *НӨАТ ногдуулалтын үндэслэлийг сайжруулах боломж*.
7. Дашдорж, Л. (2010). *Нэмэгдсэн өртгийн албан татварын зарим судалгаа*.
8. Маралмаа, Ч. (2014). *Татварын бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөө*.
9. Оюунбилэг, П. (2016). *Нэмэгдсэн өртгийн албан татварын төлөлт, хяналтын процессийн оновчлол*.
10. Өнөрмөнх, Б. (2017). *НӨАТ төлөлт, хяналтад ДАШБОАРД арга хэрэгсэл ашиглах боломж*.
11. Пунцаг, П. (2014). *НӨАТ-ын бүртгэл, тайлагналыг сайжруулах нь*.
12. Сүхээ, Д. (2014). *Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн төслийн сул талууд*.
13. Ундармаа, Э., Хишигбаяр, Л., Болор, Б. (2016). *Нэмэгдсэн өртгийн албан татварын бүртгэл, тайлагналын асуудал, илтгэл*.
14. Хишигбаяр, Л., Лхагвасүрэн, Д. (2017). Цахим (е-) баримтын хэрэгжилтийг сайжруулах нь, *Нягтлан бодох бүртгэлийн онол, практик*, 1(3), 51-58.
15. Хүлэг ХХК-ийн татварын судалгааны баг (2012). *Татварын бодлогыг боловсронгуй болгон шинэчлэх асуудлууд*.
16. Цогт, О. (2011). *НӨАТ-ын хуулийн хэрэгжилт, цаашдын чиг хандлага*.
17. Энхсүрэн, М., Баатарцогт, Б. (2017). *НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн*.
18. Жижиг дунд үйлдвэрлэлийн тухай хууль, www.legalinfo.mn
19. databank.worldbank.org. Дэлхийн Банкны мэдээлийн сан.
20. www.1212.mn. Үндэсний Статистикийн Хорооны мэдээллийн нэгдсэн сан.
21. www.mta.mn. Татварын ерөнхий газар.

